

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ БОЛОН НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ” АУДИТЫН ТАЙЛАН

Нөхөн сонгуульд оролцсон намын хороо, нэр дэвшигчид нь
сонгуультай холбоотой хандив аваагүй, зардал гаргаагүй
байна.

АУДИТЫН КОД: ХӨА-2026/106-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 86479090 Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. <https://audit.mn>

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

С.Гансүх

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn

2026 оны 09 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт.....4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5

Ерөнхий мэдээлэл.....5

Бүлэг 1. Нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлж, тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.6

1.1. Нэр дэвшигчид хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлсэн байна.6

1.2 Нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.....6

Бүлэг 2: Нөхөн сонгуульд оролцсон намын хороо, нэр дэвшигчид нь сонгуультай холбоотой хандив аваагүй, 120.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.6

2.1. Нэг нэр дэвшигч өөрийн орлогоос 120.0 мянган төгрөгийн сонгуулийн зардлын санхүүжилт бүрдүүлсэн байна.

2.2. Сонгуульд оролцсон намын хороо, нэр дэвшигчид хандив аваагүй байна.6 - 7

2.3. Нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигчээс 1 нэр дэвшигч 120.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.7

Дүгнэлт7

Хавсралт 8



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторов 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралт “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.
3. Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам хороод, нэр дэвшигчид нь хуулийн дагуу нийтэд мэдээлэх хэмжээний хандив хүлээн аваагүй болохыг дурдсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

Товчилсон үгийн тайлбар

АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
НА	Нийцлийн аудит

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Үндэслэл, зорилго

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/32 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн, орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг хянаж дүн, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, хандивын данс нээлгэсэн харилцагч банкны дансны хуулга, хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг буцаасан буюу улсын орлого болгосон баримт, бусад шаардлагатай баримт материалуудыг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 800, “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”, Монгол улсын “Төрийн аудит MNS 6817:2020” стандарт болон Аудитыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/33 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгосон.

Аудитын багийн бүрэлдэхүүн, удирдлага, зохион байгуулалт

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр чанарын хяналт хэрэгжүүлж, арга зүйгээр ханган, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар, нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны нөхөн сонгуулийг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Тариалан суманд 2 мандатад зохион байгуулахаар Сонгуулийн Ерөнхий хорооноос тогтоосон байна. Сул 2 мандатад Тариалан сумын Монгол ардын намын хорооны нэр дэвшигч болон 1 бие даан нэр дэвшигч өрсөлдөж нөхөн сонгуульд оролцсон зардлын тайлангаа ирүүлсэн байна. Тариалан сумын Монгол ардын намын хороо нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын хорооны дансгүй, нөхөн сонгуулийн мандатад өрсөлдөгчгүй тул намын хорооноос зардал гаргахаар төлөвлөөгүй тул зардлын данс нээгээгүй, зардал гаргахгүй болохоо албан тоотоор илэрхийлсэн байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/21, А/22 дугаар тушаалуудаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, нэр дэвшигч, бие даагчаас зарцуулах зардлын дээд хэмжээг сум, баг бүрээр тогтоосон бөгөөд зардлын дээд хэмжээ нь нэр дэвшигчийн

хувьд аймагт 49.8-70.6 сая төгрөг, багт 17.2-31.5 сая төгрөг, нам, эвслийн хувьд аймагт 491.5 сая төгрөг, суманд 73.2-153.3 сая төгрөг байхаар баталсан.

НЭГ. ТАРИАЛАН, АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН 2 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛСЭН БАЙНА.

1.1 Нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансыг хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3¹ -т заасны дагуу сонгуульд оролцох 1 намын нэр дэвшигч, 1 бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын дансыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор буюу 20-оос доошгүй хоногийн өмнө Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт бүртгүүлсэн байна.

1.2 Нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Нөхөн сонгуульд өрсөлдсөн Тариалан сумын Монгол ардын намын хороо нь нөхөн сонгуулийн мандатад өрсөлдөгчгүй тул намын хорооноос зардал гаргахаар төлөвлөөгүй тул сонгуулийн зардлын данс нээлгээгүй, сонгуультай холбоотой зардал гаргаагүй, тайлан ирүүлээгүй ба энэ тухай албан бичгийг хуульд заасан хугацаанд ирүүлсэн бол 2 нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3²-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж, 30 хоногт багтаан Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа намуудын салбар буюу сумын намын хороо нь орон нутгийн сонгуульд хөрөнгө бүрдүүлж оролцох боломжтой боловч Улс төрийн намын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд “**нам**” тайлан гаргана гэж заасан байгаагаас үүдэн эрх зүйн тодорхой бус тодорхой бус байдал үүсгэж байна.

ХОЁР. 2. НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМЫН ХОРОО, НЭР ДЭВШИГЧИД НЬ СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ХАНДИВ АВААГҮЙ, 120.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ЗАРДАЛ ГАРГАСАН БАЙНА.

2.1 Нэг нэр дэвшигч өөрийн орлогоос 120.0 мянган төгрөгийн сонгуулийн зардлын санхүүжилт бүрдүүлсэн байна.

Сонгуулийн зардлын тайланд хяналт хэрэгжүүлэхэд Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд Монгол ардын намын хорооноос нэр дэвшигч өөрийн цалингийн орлогоос 120.0 мянган төгрөгийн сонгуулийн зардлын эх үүсвэрийг бүрдүүлсэн бол Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлээгүй, сонгуулийн зардлын дансанд орлого хийгээгүй байна.

2.2 Сонгуульд оролцсон намын хороо, нэр дэвшигчид хандив аваагүй байна.

¹ Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

² Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

Сонгуулийн зардлын тайлан, дансны хуулганаас үзэхэд нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч нь сонгуульд өрсөлдөх хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ямар нэгэн хандив аваагүй байна.

Намын хороо, нэр дэвшигчид нь иргэн хуулийн этгээдээс хандив аваагүй байгаа тул нийтэд мэдээлэх нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

2.3 Нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигчээс 1 нэр дэвшигч 120.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд Монгол ардын намын хорооноос нэр дэвшигч 120.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан бол Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч сонгуулийн зардал гаргаагүй байна. Нөхөн сонгууль нь өрсөлдөгчгүй болсноос шалтгаалан намын салбар хороо болон нэр дэвшигч сонгуультай холбоотой зардал гаргалгүй оролцох боломжтой байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хөвсгөл аймгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн 2026 онд нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлж, хандивын тайланг ирүүлсэн байна.
2. Нөхөн сонгуульд оролцсон намын хороо, нэр дэвшигчид нь сонгуультай холбоотой хандив аваагүй, нийтэд мэдээлэх нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.
3. Орон нутгийн нөхөн сонгууль нь өрсөлдөгчгүй болсноос шалтгаалан намын хороо, нэр дэвшигчид сонгуультай холбоотой зардал гаргах шаардлага бага байсан байна.
4. Орон нутаг дахь намын салбарын хууль эрх зүйн орчин тодорхой бус, хуулийн этгээд биш байгаа нь сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй намын салбар хороодод хуулийн дагуу арга хэмжээ авах боломжгүй, сонгуулийн зардалд хяналт хийгдэхгүй байх эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Хавсралт

Нам, нэр дэвшигчдээс сонгуулийн үйл ажиллагаанд гаргасан зардлын дүн

№	Нам, нэр дэвшигчийн		Сонгуулийн үйл ажиллагаанд гаргасан зардлын дүн
	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	
1	Түмэндэмбэрэл	Отгончулуу	120,000.0
2	Энхцэцэг	Баттөгс	0.0
Нийт			120,000.0